


ШУТИС-ИЙН 2023 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Хамтын гэрээний зорилго нь ШУТИС-ийн профессор багш, ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, Хөдөлмерийн тухай хуулиар шүуд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхэд оршино.
- 1.2 Монгол улсын Хөдөлмерийн тухай хууль, Үйлдвэрчний эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, бусад холбогдох хууль, хуульчилсан актуудыг үндэслэн, ажил олгогчийг төлөөлж ШУТИС-ийн Захиргаа, хамт олных төлөөлж Үйлдвэрчний эвлэлийн хороо (ҮЭХ) /цаашид талууд гэх/ харилцан тохиролцож, энэхүү хамтын гэрээг байгуулав.
- 1.3 Хамтын гэрээ нь ШУТИС-ийн профессор багш, ажилтны цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал олгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, талуудын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх харицааг зохицуулна.
- 1.4 Хамтын гэрээ байгуулагч талуудын харьялал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдхөн нь хамтын гэрээг цушлах үндэслэл болохгүй.
- 1.5 Энэхүү гэрээ нь 2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2024 оны 09-р сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 1.6 Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талууд бие биедээ бичгээр хүсэлт гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор асуудлыг авч хэлэлцэн.
- 1.7 Хамтын гэрээний хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг Талууд хамтран боловсруулж хэрэгжүүлнэ. Ажлын төлөвлөгөөг гэрээний хавсралтаар батлах бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна. ШУТИС-д дагаж мөрдех дүрэм журмын хэрэгжилтэд гэрээнд оролцогч талууд хяналт тавьж ажиллана.
- 1.8

Хоёр. Хөдөлмерийн харилцаа, цалин хөлс, нэмэгдлийн талаар

- 2.1 ШУТИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулийн захирал нь профессор багш, ажилтантай Монгол улсын Хөдөлмерийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хөдөлмерийн гэрээг хугацаагүй байгуулах бөгөөд жил бүр дүгнэж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 2.2 МУ-ын Үндсэн хуулийн дагуу профессор багш нарын цагийн сургалтын хичээллэх цаг, цагийн тооцоог ШУТИС-д мөрдж буй цаг тооцох журмаар бүрэн тооцож, хөлсийг нь олгоно.
- 2.3 БСШУСЯ-ны “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн ажлын норм тогтоо, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журмар”-ын дагуу ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, ДаТС-ийн Ахлах сургууль, ШУТИС-Коосэн ТК-ийн ерөнхий боловсролын сургуулийн багшийн долоо хоногийн ажлын цаг 40 цаг байна. Багш долоо хоногт стандартыг хэрэгжүүлэх 34 цагтай тэнцэх ажил, б цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ. Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цагийг хичээл заах цагт зориулна.
- 2.4 ШУТИС-ийн профессор багш, ажилтны үндсэн цалинг 2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс 10 хувиар, 2023 оны 09-р сарын 16-ны өдрөөс 15 хувиар нэмэгдүүлнэ.
- 2.5 Профессор багш нарын заавал белэлүүлэх ноогдоос давсан илүү кредит цагийн нэг кредитийн үзүүлэлтээг 400 000 төгрөгөөр тооцно.
- 2.6 ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, ДаТС-ийн Ахлах сургууль, ШУТИС-Коосэн ТК-ийн ерөнхий боловсролын сургуулийн багши нарын хийж гүйцэтгэсэн илүү цагийн хөлсийг ХНХ-ын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны А/192 тоот тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 2.2-т заасны дагуу бодож олгоно.
- 2.7 “ШУТИС-ийн багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үзэлж, урамшуулахаас журам”-ын хэрэгжилтийг 2023 оны 10-р сарын 01-ний өдрөөс эхлэн сэргээж, үр дүнгийн урамшууллыг журмын дагуу дүгнэж олгоно.
- 2.8 Профессор багш нар хүрэлцээгүй, зайлсхийг тохиолдолд илүүтийн илүү цагийн хөлсийг цаг тооцох журамд зааснаар тухайн хичээлийн жилд бодож олгоно.
- 2.9 ШУТИС-ийн профессор багш, ажилтны цалин хөлсийг сард 2 удаа олгоно. Хэрэв энэ өдөр нь нийтээр амрах баярын өдөртэй давхавтал урьд өдөр нь олгоно.
- 2.10 Нийтээр амрах баярын өдөр тасарсан хичээлийг профессор, багш нар агуулгаар нь нехөх үүрэгтэй бөгөөд ийнхүү тасарсан хичээлийг багшийн гүйцэтгэлээс хасахгүй.
- 2.11 Үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаалт хавсан буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг



ШИНИЙН ХУУДАН

- гүйцэтгэсэн тохиолдолд тухайн ажилтанд хавсан гүйцэтгэж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хуртгал хувиар тооцож нэмэгдэл хөлс олгоно.
- 2.12 Биеийн тамирын багш, ажилтын спортын мастериyn нэмэгдлийг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөл зохих журмын дагуу бодож олгохыг тэдний хөдөлмөрийн гэрээнд тусган шийдвэрлэнз.
- 2.13 Мэргэшийн зэргийн нэмэгдлийг захиргаа аж ахуйн ажилтан тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа тохиолдолда холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын дагуу олгоно.
- 2.14 ШУТИС-ийн профессор багш, ажилтан өөрийн цалингийн хэмжээ болон бусад нэмэгдлийн талаар мэдээлэл авах эрхтэй. Бүрэлдэхүүн сургуулийн санхүүгийн ажилтан болон хүний нөөцийн ажилтан тухай бүрд нь мэдээлэл өгөх үүргийг хүлээнз.

Гурав. Ажил амралтын цаг

- 3.1 Ажлын цагаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан профессор багш, ажилтны ажлын цагийг суралцаж байх хугацаанд нь ажил олгогч богиносгож, үндсэн цалин, урамшууллыг бүрэн олгоно.
- 3.2 Хүүхэд хөхүүлэх, асрал завсарлагын цагийг хуульд зааснаар олгох бөгөөд энхүү цагийг ажлын цагт оруулан тооцно.
- 3.3 ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтан Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль болон ХНХ-ын сайдын 2021 оны 12-р сарын 06-ны өдрийн А/191 тоот тушаалаар баталсан журмын дагуу эзлжийн амралтаа биеэр эдэлж, эзлжийн амралтын олговроо бүрэн авна. Эзлжийн амралтаа бүрэн эдлээгүй профессор багш, ажилтны амралтын үлдсэн хоногийг заавал биеэр эдлүүлнэ.
- 3.4 Ажлын зайлшгүй шаардлагаар эзлжийн амралтаа биеэр эзэлж чадаагүй профессор багш, ажилтныг тухайн жилд нь багтааж амруулах, нөхөн амруулах боломжгүй бол мөнгөн урамшуулалт олгоно. Ажилласан нэг өдрийн мөнгөн урамшууллын хэмжээ нь тухайн албан тушаалтын үндсэн цалингийн нэг өдрийн хөлстэй тэнцүү байна.
- 3.5 Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сүл зогсoltын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлэн ажиллуулах, шилжүүлэх боломжгүй бол ажилтанд үндсэн цалингийн 75 хувиар олговор олгоно.
- 3.6 Шенийн цагаар болон нийтээр амрах баарын өдөр, долоон хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол ХНХ-ын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны А/192 тоот тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 2.2-т заасны дагуу хөлсийг бодож олгоно.
- 3.7 Ажил олгогч профессор багш, ажилтанд цалинтай чөлөө олгох асуудлыг Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.
- 3.8 БСШУСЯ-ны “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтын цалин хөлсийг тооцож олгох журам”-ын дагуу ШУТИС-ийн харьцаа ерөнхий боловсролын ахлах сургууль, ДаТС-ийн Ахлах сургууль, ШУТИС-Коосэн ТК-ийн сургалтын төлөвлөгөөний 1 цаг буюу хичээл заасан 45 минутыг ажлын нэг цагаар тооцно.

Дөрөв. Нийгмийн асуудлын талаар

- 4.1 ШУТИС-ийн багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх үлгэрчилсэн журамд заасны дагуу бүрэлдэхүүн сургууль орлогынхoo 2 хувийг багшийг хөгжүүлэх үйл ажиллагаанд төсөвлөж, зарцуулалтанд талууд хяналт тавина.
- 4.2 Хөдөлмөрийн хуулийн дагуу тэтгэврт гарах эрх нь үүссэн профессор багш, ажилтан ШУТИС-д тасралтгүй ажилласан (Гадаадад магистр, докторт суралцсан, хувиараа чөлөө авсан хугацааг тооцохгүй) тохиолдолд тэтгэврт гарахад нь дараах сарын үндсэн цалингийн хэмжээтэй тэнцэх нэг удаагийн тэтгэмжийг олгоно. Үнд:


№	ШУТИС-д ажилласан сарын тоо	Тэтгэмж авах сарын тоо	№	ШУТИС-д ажилласан сарын тоо	Тэтгэмж авах сарын тоо
1	121-156 сар	3 сарын цалин	9	241-252	11 сарын цалин
2	157-168	4 сарын цалин	10	253-264	12 сарын цалин
3	169-180	5 сарын цалин	11	265-276	13 сарын цалин
4	181-192	6 сарын цалин	12	277-288	14 сарын цалин
5	193-204	7 сарын цалин	13	289-300	15 сарын цалин
6	205-216	8 сарын цалин	14	301-312	16 сарын цалин
7	217-228	9 сарын цалин	15	313-324	17 сарын цалин
8	229-240	10 сарын цалин	16	325 сараас дээш	18 сарын цалин

ИЛД
ЭВН
ХО
У
ПГ4911
ДЭР

- 4.3 МУ-ын Засгийн газрын 2010 оны 01-р сарын 20-ны өдрийн 15-р тогтоолоор ШУТИС-д бусад сургуулиас шилжин ирсэн багш нарыг тэтгэвэрт гарахад нь тэтгэмж олгоходо боловсролын байгууллагад 15-18 жил хүртэл ажилласан профессор багш тэтгэвэрт гарахад 3 сарын; 18-21 жил хүртэл ажилласан багш тэтгэвэрт гарахад 6 сарын; 21-25 жил хүртэл ажилласан багш 9 сарын; 25 ба түүнээс дээш жил ажилласан багш тэтгэвэрт гарахад 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж тус тус олгоно.
- 4.4 ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, ДаТС-ийн Ахлах сургууль, ШУТИС-Коосэн ТК-д ЕБС-иас ирсэн Хөдөлмөрийн хуулийн дагуу тэтгэвэрт гарах эрх нь үүссэн, боловсролын байгууллагад 15-18 жил хүртэл ажилласан багш, ажилтан тэтгэвэрт гарахад нь 3 сарын, 18-21 жил хүртэл ажилласан багш тэтгэвэрт гарахад нь 6 сарын, 21-25 жил хүртэл ажилласан багш тэтгэвэрт гарахад нь 9 сарын, 25 ба түүнээс жил ажилласан багш тэтгэвэрт гарахад нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмж тус тус олгоно.
- 4.5 ШУТИС-иас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсгэлгүй “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн болон Цэргийн албан хаачгийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзлыг хангаж өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр өмнө нь тогтоолгосон ШУТИС-ийн профессор багш, ажилтан нарт хамтын гэрээнд заагдсан нэг удаагийн тэтгэмж олгдохгүй.
- 4.6 ШУТИС-д ажиллаж байгаа профессор багш, ажилтан нас барвал нэг сарын үндсэн цалинтай тэнцэх, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан нас барвал хөдөлмөрийн хөлслний доод хэмжээтэй тэнцэх буцалтгүй тусламжийг ар гэрт нь олгоно.
- 4.7 Профессор багш, ажилтны төрсөн ээзг эх, ах эгч дүү, нөхөр эхнэр, хүүхэд нь нас барвал 500000 төгрөгийн тусламж үзүүлнэ.
- 4.8 Өөрийн оршин суудаг гэр орон нь гал түймэр, үер усны гэх мэт давагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд профессор багш, ажилтанд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгоно.
- 4.9 Төрийн байгууллагад 20-иос доошгүй жил, үүнээс ШУТИС-д 10-аас доошгүй жил ажилласан ҮЭ-ийн гишүүн профессор багш, ажилтанд эзэлжийн амралтаараа магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилал, эмчилгээнд явах тохиолдолд 300000 хүртэл төгрөгийн буцалтгүй тэтгэмжийг холбогдо баримт үндэслэн 3 жилд нэг удаа олгох асуудлыг ШУТИС-ийн захиргааны ажилтанд захиргааны зөвлөлийн, бүрэлдэхүүн сургууль захирлын зөвлөлийн хураар тус тус шийдвэрлэн.
- 4.10 Сургууль, салбар нэгжийн хамт олны өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулахад зориулан Горхи дахь полигонд очих, ирэх унааны зардал болон холбогдох бусад зардлыг жилд 1 удаа тухайн сургууль, нэгж хариуцан гаргана.
- 4.11 Ахмад настныг цагаан сар, ахмадын баярын өдрийг тохиолдуулан жилд 2-оос доошгүй удаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлнэ.
- 4.12 ШУТИС-д ажиллаж байгаа профессор багш, ажилтан эрэгтэй 60, эмэгтэй 55 нас хүрэхэд нэг удаа 300000 төгрөгийн зардал гаргаж, хүндэтгэл үзүүлнэ.
- 4.13 Тус сургуульд 5-аас дээш жил хариуцсан ажилдаа идэвх зүтгэлтэй ажилласан ҮЭ-ийн гишүүн ажилтан бакалавр, магистрын түвшинд суралцах эрхийн шаардлага хангасан хүний ШУТИС-д суралцахаар сонгосон мэргэжлээр нь суралцах хугацаанд нь нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50%-иар нэг удаа хөнгөлж суралцуулна.
- 4.14 ШУТИС-ийн профессор багш, ажилтан докторын зэргийн урьдчилсан хамгаалалтаа амжилттай хийсэн бол 150000 төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгоно.
- 4.15 Багш нарын баярын өдрийг тохиолдуулан “ШУТИС-ийн профессор, багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам” болон “Оны шилдэг багши шалгаруулах журам”-д заасны дагуу шилдэг профессор багшийг шалгаруулан шагнаж урамшуулна. Урамшууллыг ШУТИС-ийн төсөвт тусгасан зардааас гаргана.
- 4.16 Профессор багш, ажилтныг орон сууцаар хангах зорилгоор арилжааны банкнууд, орон сууцны корпорац, аж ахуйн нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулж, орон сууц авах багш, ажилтныг хөнгөлөлттэй, урт хугацааны зээлд хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах үүргийг санхүү, төлөвлөлтийн газар хүлээн.
- 4.17 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Ном сурах бичгийн зөвлөл, бүрэлдэхүүн болон салбар сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр зөвшөөрөгдсөн сурах бичиг, сургалтын гарын авлагыг хэвлүүлэх, олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлэл өгүүлэл хэвлүүлэх эрх авсан профессор багш, ажилтанд хөвлөлтийг холбоотой зардлыг бүрэлдэхүүн сургуулийн Захирлын зөвлөлийн хураар хэлээцэж, шийдвэрлэн,

ИЭРЧИ
ЭДЭХИЙН
РОО
ЭДЭХ

№800429:
ЭДЭХ



- 4.18 ШУТИС-д 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа профессор багш, ажилтан хүн өвчин (эмнэл зүйн, лабораторийн аргаар мэргэжлийн байгууллагаар тодорхойжсон дүгнэлт)-ний улмаас эх орондоо болон гадаад 10 сая төгрөгөөс дээш төлбөртэй эмчилгээ хийлгэх тохиолдолд ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн шийдвэрээр харьялах нэгж нь 2 сая төгрөг, бүрэлдэхүүн сургууль, захиргаа тус бүр 200000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл

- 5.1 Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасны дагуу сургууль бүр төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зардлын 0.5%-иас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хүрц хордлого, мэргэжлэс шалтгаалсан өвчинеөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна. ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл төлөвлөгөө гаргаж хариуцан ажилана. Зарцуулалтыг жилд 2 удаа тайлагдана.
- 5.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл талууд ижил тэгш эрхтэй оролцно. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл нь хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах ажлыг төлөвлөгөө гаргаж, зохион байгуулна.
- 5.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангах, хөдөлмөр хамгааллыг сайжруулах арга хэмжээний хөтөлбөрийг УЭХ-той зөвшилцөн баталж мөрдүүлнэ.
- 5.4 Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан профессор багш, ажилтанд тус хуулийн 82.1-р зүйлд заасан хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.
- 5.5 ШУТИС-ийн Захиргаа нь УЭХ-той зөвшилцөн, Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг шинэчлэн эрчимжүүлж ажиллуулна.
- 5.6 Мэргэжийн онцгойос хамааруулан, ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, шаардлагатай хөрөнгийг 5.1-т заасан сангас гаргана. Зохих арга хэмжээг сургуулийн захиргаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан орон тооны бус зөвлөл авна.
- 5.7 Хөдөлмөр хамгаалах хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн, Стандарт, хэмжил зүйн газраас тогтоосон норм, журмын дагуу хүрэлцүүхийг хэмжээгээр захиалж, хугацаанд нь олгоно.
- 5.8 Хүнд, хортой нөхцөлд ажилладаг профессор багш, ажилтан, сургалтын мастер, архивын ажилтан /үүнд архив хариуцан ажиллаж буй албан тушаалтан хамаарна/, хортой нөхцөлд УВЧ аппарат, парафин лаа эмчилгээ хийдэг физик эмчилгээний эмч, номын санч, бохирлын слесарь, ариун цэврийн өрөөний үйлчлэгч нарт ажлын өдөр бүрээр үнийн дунг 2200 төгрөгөөр тоодож, хор саармагжуулах хүснэгийн бүтээгдэхүүн болох 0.5 литр сүүг олгоно. Эдгээр албан тушаал дээр ажиллаж буй хүн болон бүх үйлчилгээний ажилтанд харшилын сорил тавиулах ажлыг сургуулийн захиргаанаас жилд нэг удаа зохион байгуулж, гарах зардлыг 5.1-д заасан сангас гаргана.
- 5.9 Үйлчилгээний ажилтанд олгох ажлын хувцас, бараж хэрэгсэл, цэвэрлэгээний материалын чанарыг сайжруулж, хүний биеid хоргуй угаалтын бодисыг зохих нормын дагуу сургуулиуд нь хариуцан олгоно. Эдгээр зүйл чанарын шаардлага хангаж буй эсэхийг ХАБЭА хариуцсан орон тооны бус зөвлөлөөс улиралд нэг удаа шалган дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг засах арга хэмжээ авна. Тоостой /тоосонцортой/ нөхцөлд ажилладаг номын сан, архивын болон сургалтын албаны ажилтны ажлын байрны нөхцөлийг сайжруулж, агаар чийгшүүлэгч сууринуулж, архих, цэвэрлэгээний материал олгоно.
- 5.10 ШУТИС-ийн хичээлийн байруудыг жилд 2 удаа ариутгаж, халдвартай жүүлэлт, мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. Үүнтэй холбогдох зардлыг гэрээндий 5.1 дэх заалтын дагуу бүрдүүлэх хөрөнгөөс гаргана.
- 5.11 Профессор багш, ажилтны ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, хичээл зааж буй анги танхмийн агааржуулалт, эрүүл ахуй, галын аюулгүй байдлыг хангана. Подвалд байрлаж байгаа профессор багш, ажилтны өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт зэргийг эрс сайжруулж, стандарт хэмжээнд хүргэх арга хэмжээ авна.
- 5.12 ШУТИС-ийн хичээлийн байрны ариун цэврийн өрөөний тохижилтыг сайжруулж, халдварт өвчинеөс урьдчилан сэргийлэх зорилгоор гар угаах шингэн саван, ариутгач уусмал, гар хатаагч, багш нарын өрөө болон коридорт ус цэвэршүүлэгч зэргийг байршуулна.
- 5.13 ШУТИС-ийн хичээлийн байрны ариун цэврийн өрөөний тохижилтыг сайжруулж, халдварт өвчинеөс урьдчилан сэргийлэх зорилгоор гар угаах шингэн саван, ариутгач уусмал, гар хатаагч, багш нарын өрөө болон коридорт ус цэвэршүүлэгч зэргийг байршуулна.
- 5.14 ШУТИС-ийн цайны газрын тохижилт, хоолны чанар, ариун цэврийг дээшлүүлж, тогтмол ажиллагаатай болгох үүргийг ажил олгоч хүзүүнээ.

ШИГЭЛГИЙН СУРГАЛТАР ДҮГЭРЛЭЛ
ХӨДӨЛМӨР, ХАДАМДЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨДӨЛМӨР

5.15 МУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйлийг үндэслэн, ШУТИС-ийн профессор багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулна. Эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардлагах зардлыг ажил олгогч хариуцах бөгөөд 1 хүнд 40000 төгрөгөөр бодож, сургуулийн зүгээс санхүүжүүлнэ. Хэрэв ажил олгогч эрүүл мэндийн үзлэгт тухайн жилд хамруулж чадаагүй бол дараа жилийн 1-р улиралд багтаан хамруулах бөгөөд санхүүжилтийг шилжих үлдэгдлээс шийдвэрлүүлнэ.

Зургаа. Талуудын хамтын ажиллагаа

- 6.1 Мэргэжил мэдлэгийг дээшшуулж зорилгоор ажил олгогч УЭ-тэй хамtran, бүрэлдэхүүн сургуулийн удирдах албан тушаалтан, профессор багш, ажилтанд зориулан, жилд 1-ээс доошгүй удаа төрөл бүрийн сургалт зохион байгуулна.
- 6.2 Үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуультанд тухайн сонгуульт ажилтай нь холбогдуулан, сахилгын шийтгэл ногдуулах, хэлэлцээрт оролцсоных нь төлөө өөр ажил шилжүүлэх, ажил олгогчийн санаачилгаар хэлэлцээний туршид болон хэлэлцээ дууссанаас хойш нэг жилийн дотор ажлаас халахыг хориглоно.
- 6.3 ШУТИС-ийн хамтын удирдлагын байгууллагад Үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг оруулна.
- 6.4 УЭ-ийн гишүүдийн татварыг цаг тухайд нь салбар хороодын данс руу бэлэн бусаар хурааж шилжүүлэх үүргийг бүрэлдэхүүн сургууль, бусад нэгж хүлээнэ.
- 6.5 УЭ-ийн төлөөлөгчид дараах комисс, зөвлөлийн үйл ажиллагаанд заавал оролцно. Үүнд:
- Хамтын гэрээний хэрэгжилтийг хянах комисс;
 - Хөдөлмөрийн эрхийн маргтан таслах комисс;
 - Үйлдвэрийн ослын шалтгаан тогтоох комисс;
 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл.
- 6.6 Хөдөлмөрийн харилцаа, Боловсролын салбарын хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, танин мэдүүлэх тал дээр гэрээнд оролцогч талууд хамtran ажиллана.

Долоо. Гэрээний биелэлтийг хянах, мэдээлэх

- 7.1 Захиргааны зүгээс профессор багш, ажилтны санал хүснэгтийг жилд нэг удаа нэгдсэн журмаар сонсож Хамтын гэрээний биелэлт, хэрэгжилтийн талаар мэдээлнэ.
- 7.2 Хоёр тал гэрээний хэрэгжилттэй холбоотой өөрт байгаа бүх мэдээллийг нээлттэй солилцно.
- 7.3 Хамтын гэрээний хэрэгжилтэд талууд хяналт тавина.
- 7.4 Хамтын гэрээг биелүүлэх явцад үссэн саналын зөрүүтэй асуудлыг “Хөдөлмөрийн тухай” хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ажил олгогчийг төлөвлж:

ШУТИС-ийн Эрдэм шинжийн, технологийн газрын захирал

ШУТИС-ийн Сургалт, цахим цийлжилтийн газрын захирал

ШУТИС-ийн Санхүү хөроогч оруулалтын албаны дарга

БүХС-ийн захирал

ГУУС-ийн захирал

ҮТС-ийн захирал

Д.Иолмонбаатар

Н.Эрдэнэхүү

Г.Жавхлан

А.Анхбат

К.Хавалболат

Ж.Туяацэг

Ажилтныг төлөвлж:

ШУТИС-ийн дэргэдэх УЭ-ийн хорооны дарга
С.Дэлгэрмаа


ШУТИС-ийн БАС-ийн УЭ-ийн хорооны дарга
Б.Бизъясурэн

ШУТИС-ийн ГХС-ийн УЭ-ийн хорооны дарга
Б.Сонинцэрг

ШУТИС-ийн МХС-ийн УЭ-ийн тэргүүлэгч
Б.Мөнхбаяр

ШУТИС-ийн БАС-ийн УЭ-ийн гишүүн
М.Банзрагч

ШУТИС-ийн ҮХС-ийн УЭ-ийн гишүүн
М.Баттулга



Гэрээний хавсралт

2023 оны хичээлийн жилийн Хамтын гэрээний ажлын төлөвлөгөө

No	Гүйцэтгэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1.	ШУТИС-ийн дотоод үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг санхүүгийн жилээр төлөвлөх	2023.01 сар	Санхүү, төлөвлөлтийн газар
2	ШУТИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг үндэслэн ажлын байрны тодорхойлолт шинэчлэн боловсруулж, баталж мөрдөх	2023.01 сар	Захирлын ажлын алба, Хүний нөөцийн алба, ҮЭХ
3	Хөдөлмөрийн маргаан таслах комиссыг ажиллуулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа, ҮЭХ
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдал, осол, хүрц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинеэс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан сан байгуулж, зарцуулалтын төлөвлөгөө гаргаж, баталж, мөрдүүлэх	Жилийн турш	Санхүү, төлөвлөлтийн газар, бүрэлдэхүүн сургуулиудын захирлууд, ҮЭСХороод
5	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн үйл ажиллагааг жигдүүлэн ажиллуулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа
6	Ажилчад олгох ажлын хувцас, багаж хэрэгсэл, үйлчилгээний ажилчад олгох цэвэрлээгээний материал чанарын шаардлагын хангаж буй эсэхийг шалган дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг засах арга хэмжээ авч ажиллах	Улиралд нэг удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл
7	“ШУТИС-ийн багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх угзарчилсэн журам”-ын дагуу бүрэлдэхүүн сургууль бүр хөрөнгө төвлөрүүлж, зарцуулах ажлын төлөвлөгөө гаргах	2023.01 сар	Бүрэлдэхүүн сургуулиудын захиргаа, ҮЭСХороод
8	Багш, ажиллагсадад орон сууц авахад нь дэмжлэг узүүлэх, арилжааны банк, орон сууцны корпорац, аж ахуйн нэгж, хувь хүнтэй грээ байгуулах, зээлд хамруулах ажлыг эрчимжүүлж ажиллах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа
9	Хичээлийн байруудын ариунтгал, халдвартгийжүүлэлт, мэргэч, амьтан устгах ажлыг зохион байгуулах	Жилд 2 удаа	Хангамж үйлчилгээний алба, байр хариуцсан менежер
10	Цайны газруудын ариун цэвэр, хоолны чанарт хяналт тавих	Жилийн турш	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, хангамж үйлчилгээний алба
11	Хичээлийн байруудын ариун цэврийн өрөөний тохижилтийг харницаж хийлгэх. Багш нарын өрөө, коридорт ус цэвэршүүлэгч байршуулах ажлыг хийлгэх.	Жилийн турш	Хангамж үйлчилгээний алба, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, байрны зохион байгуулагч
12	Багш нарын өрөөний галын аюулгүй байдлыг хангах, агааржуулалт, гэрэлтуүлэг зэргийг стандартын шаардлагын дагуу сууринуулж, ажиллуулах	Жилийн турш	СТГазар, бүрэлдэхүүн сургуулиудын захиргаа, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл
13	ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газар